МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 25 өдөр Дугаар А/122 Мөрөн сум

Мал, амьтны сэг зэм устгал,
халдваргүйтгэлийн ажил
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, Засгийн газрын 62 дугаар тогтоол, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2024 оны А/40 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, булшлах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажлыг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор зохион байгуулж, шаардлагатай хүн хүч, техник, шатахуун, шаардагдах бусад зардлыг шийдвэрлэж ажиллахыг сумдын Засаг дарга нарт, мэргэжил арга зүй, удирдлагаар ханган, ажлын явц, чанар гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Л.Ариунаа) нарт тус тус үүрэг болгосугай.

2. Сэг зэм устгал, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг орон нутагт зохион байгуулж, хамтран ажиллахыг Хүнс хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр)-т, Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-д, хэрэгжилтийн тайланг 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа) нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх), Онцгой байдлын газрын дарга, хошууч (С.Ганболд)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712010359